



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 03 сарын 06 өдөр

Дугаар А/85

Мандсговь

Г Ажлын хэсэг байгуулах тухай Т

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс санхүүжигдэх "Эрдэнэдалай суманд хог зөөврийн автомашин нийлүүлэх" ажлын шууд гэрээ байгуулахад хуулийн шаардлага хангасан гүйцэтгэгчийн үнийн санал авч шалгаруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: А.Нарантуяа /НБХ-ийн дарга/

Гишүүд: С.Энхжаргал /"Нийтлэг үйлчилгээ" ОНӨҮГ-ын менежер/

М.Бат-Эрдэнэ /ОНӨГ-ын мэргэжилтэн/

Хоёр. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34.2-ын дагуу зохион байгуулан гүйцэтгэгч сонгосон ажлын хэсгийн дүгнэлтийг гаргахыг ажлын хэсэг /А.Нарантуяа/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О БАТ-ЭРДЭНЭ

0200261